

## ГХЯ-НЫ ХӨРШ ОРНУУДЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ Т.ТӨГСБИЛГҮҮНИЙ ХЭЛСЭН ҮГ

*Эрхэм хүндэт Элчин сайд Ван Сяолун,  
Эрхэмсэг ноён Жао Цижэн,  
Хатагтай, ноёд оо,  
Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.*

Монгол Улсын ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, БНХАУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ хамтран зохион байгуулж буй "БНХАУ дахь шинэчлэлт, нээлттэй бодлогын гүнзгийрэлт-Монгол, Хятадын харилцааг хөгжүүлэх шинэ боломж" сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд оролцож, та бүхэнтэй уулзаж байгаадаа баяртай байна.

Улирч буй 2013 он Та бидний хувьд онцгой үйл явдлаар дүүрэн түүхэн он жил болж байна. Хоёр орны өндөр дээд түвшний харилцан айлчлал идэвхитэй өрнөж, улс төрийн итгэлцэл, ард иргэдийн харилцан ойлголцол нэмэгдэж, худалдаа, эдийн засгийн салбарын бодит хамтын ажиллагаа шат ахин хөгжиж ирлээ. Энэ онд БХАТИХ-ын БХ-ны дарга У Бангуо, БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн Ян Жэчи, БХАТИХ-ын БХ-ны дэд дарга Сянба Пинцую, ХКН-ын Улс төрийн товчооны гишүүн Жао Лэзи нар тус тус Монгол Улсад айлчилсан. Мөн Монгол Улсын их хурлын дарга З.Энхболд БОАО-гийн олон улсын чуулга уулзалтад оролцох үеэрээ БНХАУ-ын дарга Си Зиньпин, БХАТИХ-ын Байнгын хорооны дарга Жан Дөзян нартай уулзсан билээ.

Кыргызийн нийслэл Бишкек хотноо болсон ШХАБ-ын гишүүн орнуудын төрийн тэргүүн нарын дээд түвшний уулзалтад Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж оролцох үеэрээ БНХАУ-ын дарга Си Зиньпинтэй уулзан, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны зарим асуудлаар санал солилцсон. Мөн Монгол Улсын Батлан хамгаалахын сайд, Зам тээврийн сайд, Эдийн Засгийн хөгжлийн сайд нар Хятад Улсад, БНХАУ-ын БХЯ-ны Жанжин штабын орлогч дарга, Соёлын сайд нар Монгол Улсад тус тус айлчилсан юм. Эдгээр

айлчлал хоёр орны батлан хамгаалах, соёл хүмүүнлэг, дэд бүтэц, эдийн засгийн бодит хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чухал түлхэц үзүүлээ. Монголын тал өндөр, дээд түвшинд ярилцаж тохиролцсон зүйлийг бодит ажил хэрэг болгох талаар ихэд анхаарч, Засгийн газрын тэргүүнээр ахлуулсан ажлын хэсэг байгуулж, тусгай төлөвлөгөө гарган ажиллаж байгааг дуулгахад таатай байна.

Энэ оны 10 дугаар сард Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг БНХАУ-д албан ёсны айлчлал хийж Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Ли Көцянтай албан ёсны хэлэлцээ хийж, БНХАУ-ын дарга Си Зиньпин, БХАТИХ-ын БХ-ны дарга Жан Дөзян нарт бараалхсан. Энэхүү айлчлал нь Монгол Улсын шинэчлэлийн Засгийн газрын тэргүүний БНХАУ-д хийсэн анхны айлчлал байсан бөгөөд Хятадын шинэ үеийн удирдагч нартай өрнүүлсэн яриа, хэлэлцээ амжилттай болж Монгол Хятадын харилцааны шинэ хуудсыг нээсэн билээ. Айлчлалын үеэр хоёр тал Монгол, Хятадын стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр /цаашид "Дунд, урт хугацааны хөтөлбөр" гэх/ болон хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны 11 баримт бичигт гарын үсэг зурсан нь хоёр орны бодит хамтын ажиллагааг урагшлуулан хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болов.

Монголын тал хоёр улсын хооронд уламжлал болон тогтсон дээд, өндөр түвшний харилцан айлчлал, яриа хэлэлцээг цаашид үргэлжлүүлэхийн төлөө байдаг. 2014 онд хоёр орны удирдлагуудын харилцан айлчлалыг зохион байгуулахаар хоёр тал ярилцаж байна. Ирэх онд хоёр талын хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ой тохионо. Энэ ойг тохиолдуулан 2014 оныг "Монгол-Хятадын соёл, урлаг, хүмүүнлэгийн солилцооны жил" болгож, соёл урлаг, хүмүүнлэгийн өргөн хүрээтэй арга хэмжээ зохион байгуулахаар тохиролцлоо. Энэ ажлын хүрээнд хоёр тал хамтын ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллахаар тогтоод байна.

Ийнхүү дүгнэн хэлэхэд өнөөдөр Монгол, Хятадын харилцаа түүхэн дэх хамгийн таатай үедээ явж байна. Үгийнхээ төгсгөлд миний бие, хоёр талаас хамтран зохион байгуулж буй энэ удаагийн эрдэм шинжилгээний хуралд

амжилт хүсэхийн ялдамд цаашид ч ийм арга хэмжээг тогтмол зохиож байх нь зүйтэй гэсэн санал дэвшүүлж байна.

*Анхаарал тавьсанд баярлалаа.*